



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/468

Арвайхээр

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.18 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн албан бичгийг үндэслэн тусгай зөвшөөрөл сунгах нэр бүхий 2 эмнэлэг, шинээр олгох 1 эмнэлгийг нэгдүгээр, тусгай зөвшөөрөл сунгах нэр бүхий 7 эмийн сангуудыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Цагдаагийн газар (О.Ганбат) нарт тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



О. БАТЖАРГАЛ

011101037

Аймгийн Засаг даргын 2020 оны
10 дугаар сарын 10-ны өдрийн 488 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ, СУНГАХ,
ЭМНЭЛГИЙН НЭР, ЧИГЛЭЛ, ОЛГОХ ХУГАЦАА

д/д	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Олгох хугацаа
1	Түшиг дөлгөөн Өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил
2	Хурд хувийн хэвшлийн лаборатори	Лабораторийн үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил
3	Додо шүдний хувийн хэвшлийн эмнэлэг	Шүдний тусламж үйлчилгээ	Хархорин сум	Шинээр олгох	3 жил

Аймгийн Засаг даргын 2020 оны
10 дугаар сарын 20 ны өдрийн 1168 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ ЭМИЙН САНГУУДЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

д/д	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Олгох хугацаа
1	Агьт хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сум	Сунгах	5 жил
2	Арвайн ундарга хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сум	Сунгах	5 жил
3	Энэрэлт хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Уянга сум	Сунгах	5 жил
4	Энхэд мөнх хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сум	Сунгах	5 жил
5	Монос-Өвөрхангай хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сум	Сунгах	5 жил
6	Арвин лхам-Очир хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Бат-Өлзий сум	Сунгах	5 жил
7	Хангай хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Хархорин сум	Сунгах	5 жил